

“НУУЦ ТОВЧОО”-Г НУХАЦТАЙ СУДАЛСАН БҮТЭЭЛ

М.Зулькафил*
*МУИС-ийн Эмерит профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D.)

**МУИС-ийн Эмерит профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D.)*

Түлхүүр үг: нийтлэл зүй, “Монголын нууц товчоо”, нийтлэлийн шинж, бичлэгийн төрөл зүйл, нийтлэл зүйн онол, түүхэн эх сурвалж

Сүүлийн жилд хэвлэгдэж гарсан сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүдийн дотроос сэдвийн хувьд нэн шинэлэг, судлаачаас багагүй цаг хугацаа, хүч хөдөлмөр, эрэл хайгуул, бүтээлч сэтгэлгээ, нийтлэл зүйн багагүй мэдлэг, баримт мэдээлэл шаардсан чамбай бүтээл бол сэтгүүл зүйн доктор Мөнхөөгийн Наранчимэгийн “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй” (нийтлэл зүйн онолын үзэл баримтлалд тулгуурлан “Монголын нууц товчоо”-ны бичлэгийн арга, хэлбэрт хийсэн шинжилгээ) хэмээх нэг сэдэвт бүтээл юм. Энэ бол зохиогч “Монголын нууц товчоо” – нийтлэлийн дурсгал болох нь” сэдвээр сэтгүүл зүйн докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт зохиолоо бие даасан ном болгон хэвлээд уншигч түмэнд толилуулж буй хэрэг юм.

Юуны өмнө залуу судлаач урьд өмнө сэтгүүл зүйн докторын зэрэг горилсон бүтээлийн түвшинд судлагдаж байгаагүй, хэл шинжлэл, утга зохиол, түүх, эх бичвэр судлал, утга зүй, цэргийн, эдийн засгийн, сэтгэл зүйн, гүн ухаан, улс төр, угсаатны зүй, ёс зүй, удирдахуйн зэрэг нийгэм-хүмүүнлэгийн олон салбар шинжлэх ухааны судлагдахуун болж байсан нэлээд нарийн төвөгтэй сэдвийг сонгон авч түүнийг нийтлэл зүйн үүднээс судалж, докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлийн түвшинд шинжилгээ хийснийг сайшаан дэмжихийн зэрэгцээ зохиогчийн зориг зүтгэлийг үнэлэх хэрэгтэй юм. Энэ бол нэг талаар, манай залуу судлаачид урьд өмнө харьцангуй бага судлагдсан, судлахыг сэтгүүл зүйн судлалын өнөөгийн

байдал шаардаж буй чухал сэдвийг сонгон авч, тухайн сэдвийг улам гүнзгийрүүлэн судлах үүд хаалгыг нээж өгч байгаагийн, нөгөө талаар манай сэтгүүл зүйн судалгааны сэдвийн хүрээ өргөжиж, сэтгүүл зүйн хөгжил, хэтийн төлөвийг зөв ойлгож, арай өөр өнцгөөс харж, хандаж, шинэлэг зүйлийг эрж хайж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьж буйн илрэл юм. Энэ бол өнөөгийн сэтгүүл зүй судлалд ажиглагдаж буй шинэлэг хандлага бөгөөд цаашид сэтгүүл зүйн эрдэмтэн судлаачид, сэтгүүл зүйн сургалт, судалгааны байгууллагууд болон сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд бүх талаар дэмжин ажиллах нь зүйд нийцнэ. М.Наранчимэгийн судалгааны ажлын удирдагч доктор, профессор Т.Баасансүрэн: ”Энэ бол маш сайн судалгаа. Сүүлийн тав, зургаан жилийн нүсэр хөдөлмөр, хүчин чармайлалтын үр дүн. Зориг гаргаж барьж авсан, асуудлаа амжилттай шийдвэрлэж чадсан. Үлдэцтэй, чамбай ажил болсон. ...энэхүү ажлын шинэлэг тал нь Монголын сэтгүүл зүйн судлалд анх удаа “Монголын нууц товчоо” хөлгөн их судрыг оруулж, шинжлэх ухааны үүднээс буурь суурьтай нягтлан судлаад, докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиолын түвшинд боловсруулсанд оршино” (Баасансүрэн, 2019) гэж үнэлж, дүгнэсэнтэй санал нэг байна.

Судлаач М.Наранчимэгийн бүтээлийн “Монголын нууц товчоо”-г нийтлэл зүйн онолын үүднээс авч үзэх нь” хэмээх нэгдүгээр бүлэгт нийтлэл зүйн онолын үндсэн үзэл баримтлалд тулгуурлан “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн дурсгал болох үндэслэлүүдийг нэлээд дэлгэрэнгүй тайлбарлаж, түүнийг тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралыг тусгаж байсан жишээ баримтаар нотлохыг зорилго болгожээ. Ингэхдээ эхлээд энгийн уншигч төдийгүй зарим судлаачийн хувьд ч хараахан нэг мөр ойлголттой болж чадаагүй сэтгүүл зүйн “нийтлэл”, “нийтлэл зүй” хэмээх ойлголтуудыг эрдэмтэн судлаачдын бүлээлүүдэд тулгуурлан үндэслэл сайтай тайлбарлаж, “...нийтлэл нь оршин буй тухайн цаг үеэ тусгаж, амьдрал ажил үйлсэд нөлөөлөх чадвартай байж, илүү шуурхай хүрдгээрээ онцлог. Хүнд шууд хүрч байгаа мэдлэг мэдээлэл, сургаал номлол, гэгээрүүлэгч, танин мэдүүлэгч шинжтэй байх нь нийтлэлийн амин чухал шалгуур үзүүлэлт мөн. Өөрөөр хэлбэл нийтлэлийн мөн чанар нь үгийн урлагийг эзэмшсэн, нийгмийн аль ч хүрээний иргэн тухайн нийгэмд өрнөж буй чухал үйл явдал, үзэгдлийн талаар баримт нотолгоотой, өөрийн амьдралын туршлага, мэдлэг, үнэт зүйлсийн үндсэн дээр олон түмэнтэй үзэл бодлоо хуваалцаж болдог онцлогтой. ...Нийтлэл бичихэд шалтгаан хэрэгтэй. Тэр нь бидний аж төрж байгаа эрин цаг үеийн нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, зан суртахуун зэрэг олон салбарт болж байгаа үйл явдал, үзэгдэл юмс юм” (Наранчимэг, 2019) гэж нийтлэлийн шалгуур, мөн чанарыг илэрхийлж чадахуйц гол шинжүүдийг үндсэндээ зөв гаргаж чадсан байна. Мөн нийтлэл хэмээх ойлголтыг сэтгүүл зүйн, нийтлэл зүйн, утга зохиолын онолын үндсэн үзэл баримтлал, гол ойлголтуудтай холбон тайлбарласан нь

арга зүйн хувьд оновчтой болсны зэрэгцээ сонгож авсан сэдвийн үндсэн асуудлыг зөв гаргаж, үндэслэл сайтай, итгэл үнэмшилтэй тодорхойлоход нөлөөлжээ.

Судлаач “Монголын нууц товчоо”-г (цаашид “МНТ” гэж бичих) нийтлэлийн дурсгал гэж үзэхдээ энэ талаар бичигдсэн сэтгүүл зүй судлаач эрдэмтдийн санал бодол, дүгнэлтийг, тэр дундаа доктор, профессор Т.Баасансүрэн, Л.Норовсүрэн, сэтгүүлч Х.Цэвлээ нарын дүгнэлтийг, мөн өөр салбарын судлаачдын санал бодлыг түлхүү ашиглаж, тэднийг улам гүнзгийүүлж, өөрийнхөө санаа бодлоор баяжуулсан нь ажиглагдлаа. Мөн бодол санаагаа шууд илэрхийлэж, сэтгэл хөдлөлийг өдөөх, тухайн цагийн нийгмийн түүхийг бичих, монгол үндэстний эрхэлдэг аж ахуй, эдэлж хэрэглэдэг зүйсийн талаарх мэдээлэл арвин байх, үйл явдлыг нийтлэл-уран сайхны аргаар туурвин бичих, үнэн бодит амьдралын үйл явдал түлхүү тусгасан, хууч яриа, ардын билиг сургаал, зүйр цэцэн үгсийг баримт, үйл явдалтай уялдуулан ашигласан нь “МНТ”-г нийтлэлийн өвөрмөц шинж төрхтэй болгож чадсан (х.69), “хаанас нь ч уншсан түүний утга санаа нь алдагдахгүйгээр барахгүй жижиг зүйлээс ч тодорхой мэдээллийг авч болох зохиомжтой бичигдсэн” (х.66) зэргийг үндэслэл болгон тайлбарлажээ. Үүнийг проф. Л.Норовсүрэн: “...М.Наранчимэг “МНТ”-г нийтлэлийн дурсгал гэж үзэхдээ нийтлэл нь... ямар ч хэлбэртэй байлаа гэсэн нийгэмд шууд хандаж, үзэгдэл үйл явдлын тухай үнэн бодитой зүйлийг өгүүлж, нийгэм болоод хүний амьдрал, ажил үйлсэд тус болж, санаа сэрэмж авахуулах үр нөлөөтэй байх ёстой гэсэн онолыг үндэс болгосон нь уг түүхэн сурвалжийг тухайн цаг үеэ тусгасан нийтлэл байжээ гэж итгэх үндэс болсон гэж үзэж байна” (Норовсүрэн, 2019) гэж тодотгон дүгнэжээ.

Судлаач “Монголын нууц товчоо”-н дахь нийтлэлийн зүйлс, тэдгээрийн төрөл, зүйлийн тухай” хэмээх хоёрдугаар бүлэгт Их Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн тогтолцоо “МНТ”-нд туссан байдлын талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлж, “МНТ” -нийтлэлийн анхдагч дурсгал болохыг зарим эрдэмтний судалгаагаар баталгаажуулсны зэрэгцээ “МНТ”-н дахь мэдээ мэдээлэл, нийтлэл-уран сайхны бичвэрүүдэд шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгчээ. Энэ бүлэг дэх сэтгүүл зүй судлаач бидний анхаарлыг илүү ихээр татах хэсэг бол 2.1 буюу “МНТ”-н дахь мэдээ мэдээлэл, нийтлэл-уран сайхны бичвэрүүд” хэмээх дэд бүлэг юм.

Судлаач нийтлэлийн шинжийг түлхүү агуулж буй хэсгүүдийг сонгон авч, агуулгын шинжилгээ (контент-анализ) хийх замаар бичлэгийн төрөл, зүйл, хэлбэрүүдийг тодорхойлохыг зорьж, “...орчин үеийн нийтлэлийн тодорхой төрөл зүйлүүдэд хамаатуулан ангилж болох зүйлүүд олон байгааг” (Наранчимэг, 2019) гярхай ажиглаж, зөв сонгон авчээ. Ингэхдээ баримтат нийтлэл мөн болохыг батлахын тулд түүний бичлэгийн хэлбэр,

агуулгад дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн нийтлэлийн бичлэгийн төрөл, зүйлтэй харьцуулж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар тухайн бүтээлийг нийтлэлийн бичвэртэй адил төстэй байдлыг гаргасан нь арга зүйн хувьд зөв болжээ. Тухайлбал, “МНТ”-ны “Тэр цагт Есүхэй баатар, Татаарын Тэмүжин-үгэ, Хори-буха зэргийн Татаар хүнийг барьж ирэхэд жирэмсэн байсан Өэлүн үжин, Ононы Дэлүүн болдог гэдэг газар Чингис хааныг төрүүлжээ. Чингис төрөхдөө баруун гарт шагайн чинээ нөж атган төржээ. Татаарын тэмүжин-үгээг барьж ирэх цагт тохиолдож төрөв” (Дамдинсүрэн, 1990) хэмээх 59 дүгээр зүйлийг товч мэдээнд тавих 5W&1Н-ийн шалгуураар шинжилж,

“Хэзээ: Есүхэй баатар, Татаарын Тэмүжин-үгэ, Хори-буха зэргийн Татаар хүнийг барьж ирэхэд

Хаана: Ононы Дэлүүн болдог гэдэг газар

Хэн: Өэлүн үжин

Хэнийг: Чингис хааныг

Яав: Төрүүлжээ

Яаж: Төрөхдөө баруун гарт шагайн чинээ нөж атган төржээ” гэх зэргээр задлан бичвэрийн төрөл, зүйлийг тодорхойлжээ. Мөн 109 дүгээр зүйлийг дэлгэрэнгүй мэдээний, 229 дүгээр зүйлийг сурвалжилсан тэмдэглэлийн, 70 дугаар зүйлийг ярилцлагын, 252 дугаар зүйлийг шүүмжилсэн тэмдэглэлийн, 281 дүгээр зүйлийг тайлангийн, 279 дүгээр зүйлийг асуудал дэвшүүлсэн өгүүллийн, 94 дүгээр зүйлийг дурсамж тэмдэглэлийн шалгуураар шинжилж, “...сонгож авсан дээрх бичвэрүүдэд ерөнхий агуулгын хүрээ, тухайн мэдээллийг бичсэн арга барил, бодит баримтад тулгуурлан бичсэн байдал, хөндөн бичсэн сэдэв зэрэг шнжээрээ орчин үеийн нийтлэлийн бичлэг болох мэдээ, захидал, ярилцлага, тайлан, тэмдэглэл зэрэг бичлэгийн зүйлүүдтэй тохирч байна” (Наранчимэг, 2019) гэж үзжээ. Судлаач энэхүү судлагааны үндсэн дээр “МНТ”-нд сэтгүүл зүйн төрөл, зүйлийн шалгуурыг хангасан 54 мэдээ, 22 ярилцлага, 10 сурвалжилсан тэмдэглэл, 69 тэмдэглэл, 11 өгүүлэл, 5 захидал харилцааны мэдээ, тайлан, мөн уг жанрын шинж тэмдгийг өөртөө агуулсан атлаа бусад жанрын элементүүдтэй холилдсон нийт 111 нийтлэл байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ бол проф. Т.Баасансүрэнгийн хэлсэнчлэн “...нүсэр их хөдөлмөр, олон талын судалгаа шинжилгээний үр дүн мөн” (Баасансүрэн, 2019) юм.

“Аливаа шүүмжийн үндсийг түүний хэлбэр, хэмжээнээсээ үл шалтгаалан ямар нэгэн бүтээлийн тухай санал бодол, юуны өмнө шүүмжлэлт санал бүрдүүлдэг” (Тертычный, 2010) учраас залуу судлаач дараа дараагийн бүтээлд анхаарч, засаж залруулах шаардлагатай зарим зүйлийг тэмдэглэн хэлэх нь зөв гэж үзлээ.

Судлаач Сократ, Платон, Энгельс, Луначарскийгээс эхлээд орчин үеийн сэтгүүл зүй судлаачдын бүтээлээс иш татаж, 284 судалгааны бүтээл, түүхэн эх сурвалжийг ашиглажээ. Энэ бол тооны хувьд хангалттай бөгөөд үүний 165-ыг зөвхөн нэгдүгээр бүлэгт ашигласан байна. Харин сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлд харьцангуй бага хандсан байна гэсэн сэтгэгдэл төрүүлэхээр болжээ. Зарим эшлэл, ялангуяа сэтгүүл зүйтэй холбоогүй бүтээлүүдээс авсан эшлэл нь оновчтой бус байгаагийн зэрэгцээ шууд бус эшлэл, эсвэл эх сурвалжийг огт заагаагүй эшлэл цөөнгүй байна. Ер нь судалгааны бүтээлд шууд бус буюу өөр судлаачийн ашигласан эшлэлийг өөрийн бүтээлд ашиглах тохиолдол нэн ховор байдаг. Цаашид эшлэлийг өөрийн санаа бодлыг баталж нотлох, бусдын санал, дүгнэлтийг үгүйсгэх, тодорхой санаа бодлыг агуулж буй догол мөртүүдийн хоорондох логик холбоог сайжруулахын тулд ашиглахыг анхааралдаа авч, хэний бүтээлээс авсан эшлэлийг хаана, яаж, яагаад ашилах вэ гэдгийг сайтар бодох нь чухал юм.

Дээр дурдсан нийтлэлийн дурсгал болох үндэслэлүүдийн зарим нь нийтлэл зүйн шалгуур, хэм хэмжээ, мөн чанар, үндсэн шинжийг ямар нэг хэмжээгээр агуулж, утга санаа нь тохирч байгаа боловч зарим нь хэт өрөөсгөл, гэнэн ч гэмээ дүгнэлт, тайлбар байна. Ардын аман зохиолын шинж, зүйр цэцэн үг, хууч яриа орсон, уран сайхны аргаар бичсэн бол нийтлэл болох ёстой мэт, “МНТ” “...өдөр тутмын сонины бичвэртэй адилтгаж болохуйц загвараар бичсэн” (х.66), “Өнөөдөр” сонинд нийтлэгдсэн сэтгүүлч Л.Чимэгийн “Монголын нууц товчоо”-ны дэлгэцийн анхны хувилбар мэндэллээ” хэмээх өдрийн сурвалжилга “МНТ” -г нийтлэлийн бүтээл мөнийг баталж буй жишээ мөн” (х.68) гэх мэт үндэслэл багатай, сэтгэлийн хөдөлгөөнөөр хийгдсэн дүгнэлтийг сайн тунгаан бодож, эргэж хармаар санагдсан. Зарим газарт нь эрдэмтэн судлаачдын өөр өнцгөөс хандаж, өөр утга санаатай дүгнэлтийг хүчээр тухайн бүтээлийн нийтлэлийн шинжтэй холбон тайлбарлах гэсэн орлолго ч мэр сэр байгааг хэлэх нь зүйд нийцнэ.

Өөр нэг цаашдын бүтээлүүдэд анхаарууштай зүйл бол зарим нэр томъёог хэт дураараа ашигласан байдал ч мэр сар ажиглагдаж байна. Тухалбал, нийтлэл зүйн онол, нийтлэлийн онол, эсвэл аман нийтлэл, нийтлэлч шинж г.м. Нийтлэл бол тодорхой нэг бүтээлийг илэрхийлж буй учраас нийтлэлийн онол гэж хэлэх нь учир дутагдатай, харин нийтлэл зүйн онол гэвэл өөр хэрэг. Зарим орос номын нэрийг буруу бичсэн нь техникийн алдаа байх магадлалтай боловч судалгааны бүтээлд маш сайн нягтлах хэрэгтэй. Тухайлбал, Ю.О.Суровцевын “О публицистике и публицистичности” хэмээх бүтээлийн “тухай” гэсэн санааг илэрхийлдэг “о”-г орхиод “Публицистике и публицистичности” гэж бичснээс бүтээлийн нэр нь өөр санааг илэрхийлэхээр болжээ. М. Н. Ким нарын “Технология создания журналистского произведения” гэдэг номыг “Сэтгүүл зүйн

бүтээлийг туурвих гарын авлага” (х.64) гэж буруу орчуулах, Ш.Гаадамбын “Некоторые художественные особенности “Сокровенного сказания” гэдэг өгүүллийг “Монголын нууц товчоо” -уран зохиолын дурсгал мөн” (зүй нь “МНТ”- ны зарим уран сайхны онцлог” юм) гэж өөрөөр орчуулах, нэг үгийг киргиз, хиргис, хиргиз г.м. олон янзын хувилбараа бичсэн нь ажиглагдлаа.

Судалгааны бүтээлд аливаа дүгнэлтийг хоёрдмол санаагүйгээр шууд нотлох аргаар бичдэг дэг жаягтай байдаг. Харин М.Наранчимэгийн бүтээлийн зарим газарт “...үзэж болмоор сэтгэгдэл төрүүлж байна”, “... ашиглаж байсан явдал гэж болохоор байна” гэх мэт эргэлзэж байгаа мэт дүнэлт цөөнгүй байгааг дараа дараагийн бүтээлүүдэд анхаарах шаардлагатай юм.

Дүгнэж хэлэхэд сэтгүүл зүйн доктор М.Наранчимэгийн “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй” бүтээл нь багагүй хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулсан, олон жилийн уйгагүй хөдөлмөр, эрэл хайгуул, бүтээлч сэтгэлгээний үр дүнд бүтсэн нэн шинэлэг бүтээл болжээ. “Монголын нууц товчоо”-гоор докторын зэрэг хүртсэн сэтгүүл зүйн анхны эрдэмтэн болох М.Наранчимэгийн энэхүү бүтээл нь сэтгүүл зүйн судалгааны салбарт цоо шинэ зам мөр гаргасан, хөлгөн их судрыг цаашид гүнгийрүүлэн судлах үүд хаалгыг нээж өгсөн мэдээллийн багтаамж, үнэлэлт дүгнэлт сайтай, танин мэдэхүйн ач холбогдол өндөр чамбай бүтээл болсныг онцлон тэмдэглэж байна.

Эшлэл

Баасансүрэн Т. 2019. Бяцхан түүх // “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй”. УБ., х.11, 13.

Наранчимэг М. 2019. “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй”. УБ., х.25-26, 155, 193.

Норовсүрэн Л. 2010. Эрдэм шинжилгээний ажлын удирдагчийн тодорхойлолт // “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй”. УБ., х.301.

Дамдинсүрэн Ц. 1990. Монголын нууц товчоо. УБ., х.38.

Тертычный А.А. 2010. Аналитическая журналистика. М.: Аспект пресс. с.258.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Баасансүрэн Т. 2009. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. УБ.

Дамдинсүрэн Ц. 1990. Монголын нууц товчоо. УБ.

Зулькафиль М. 2018. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

- Зулькафиль М. 2009. *Сэтгүүлчийн ур чадвар-2*. УБ.
- Наранчимэг М. 2019. “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй”. УБ.
- Норовсүрэн Л. 2025. *Сэтгүүл зүйн нэвтэрхий толь*. УБ.
- Тертычный А. 2010. *Аналитическая журналистика*. М.
- Тертычный А. 2005. *Жанры периодической печати*. М.

Summary

This review evaluates journalistic researcher Dr. M. Naranchimeg’s monograph entitled “The Secret History of the Mongols” (an analysis of the recording methods and forms of “The Secret History of the Mongols” based on the theoretical concept of journalism), discussing its achievements and some shortcomings in detail. On the basis of these assessments, the review concludes that the author approached the chosen topic from various angles in a creative manner, thoroughly researched the subject, made a clear contribution by studying the “The Secret History of the Mongols” in connection with other social sciences.

Keywords: publicism, “The Secret History of the Mongols”, characteristics of publication, жанре, journalism theory, historical sources